

ХУУЧИН ГЭРЭЭНИЙ СУУРЬ Курсын гарын авлага

Пентатух
Балар Эртний Түүх
Аврахаам Эцэг

КУРСЫН ТАНИЛЦУУЛГА

Хуучин Гэрээний эхний таван номыг Пентатух гэж нэрлэдэг. Эдгээр ном нь Эзэн ертөнцийг хэрхэн бүтээснээс эхлээд Израилчууд хэрхэн Амласан Нутагт орохоор зэхэж байгаа хүртэлх түүхийг өгүүлдэг. Гэвч Пентатухын таван ном нь Бурханы сонгосон ард түмний түүхэн намтар уу эсвэл түүнээс ч илүү зүйлийг өгүүлдэг үү? Хуучин Гэрээний Суурь курсийн хичээлүүд Эхлэл болон Гэтлэл номыг судлах бөгөөд тус номуудын бичигдсэн зорилгууд, анхны уншигчдад дамжуулсан утга санаа болон бид энэ номуудаас юу сурч хэрэгжүүлэх ёстой тухай үздэг. Тус курс нь Гурав Дахь Мянган үйлчлэлээс боловсруулсан *Пентатух*, *Балар эртний түүх* болон *Аврахаам Эцэг* хэмээх гурван цуврал хичээлүүдээс бүрддэг. Уг цувралуудыг Др.Скотт Рэдд болон Др.Ричард Л. Пратт Жр нар хөтлөн явуулдаг бөгөөд олон өөр профессорууд ч оролцсон.

КУРСИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД БА ХИЧЭЭЛҮҮД

Зорилго

Уг курсийн хичээлээр бид дараах зоригтонд хүрэх болно:

1. Та энэ курсын бүх зааварчилгаа, даалгаврыг хэрэгжүүлснээр Пентатухын номуудын бичигдсэн анхны зорилго, тухайн үеийн уншигчиддаа хүргэсэн үндсэн санаа болон өнөөгийн бидэнд юу хэрэгжүүлэхийг уриалж байгааг ойлгох болно гэж бид найдаж байна.
2. Та итгэлээр өсөж, Бурханы нигүүлсэл болон Түүний бүхнийг захирагч хайр, замчлалд найдаж сурна гэж бид итгэж байна.
3. Та Пентатухын номуудаас суралсан зүйлсээ бодит амьдралдаа хэрэгжүүлэн итгэлийн амьдралаар илүү тууштай явах байх гэж бид бас итгэж байна.

Зорилтууд

Та доорх зорилтуудыг хэрэгжүүлснээр дээрхи зорилгууд биелэх болно:

1. Шалгалт сорилуудад хангалттай оноо авах. Ингэснээр та Пентатухын номуудын бүтэц, агуулга, анхны утга болон орчин үеийн хэрэгжүүлэлтийн тухай мэдлэгээ өөрийн болгож чадсан эсэхээ харуулах болно.

2. Суралцах хөтчид буй хэрэгжүүлэх асуултуудад хариул. Энэ нь таныг уг курсээс сурсан зүйлсээ амьдралдаа хэрхэн хэрэгжүүлсэн болохыг илтгэнэ. Ялангуяа та Бурханы нигүүлсэл болон Түүний бүхнийг захирагч хайр, замчлалд найдаж, итгэлээр амьдарч байгаа үед энэ нь маш чухал юм.

Хуучин Гэрээ Судлалын Суурь Курсийн хичээлүүдийн нэрс

1. Пентатухын танилцуулга
2. Төгс төгөлдөр дэлхий
3. Алдагдаж, дахин олдсон аз жаргал
4. Хүчирхийллээр дүүрэн хорвоо
5. Зөв чиглэл
6. Абрахамын амьдрал: бүтэц, агуулга, эх утга
7. Абрахамын амьдрал: Орчин үеийн хэрэгжүүлэлт
8. Эцэг Иаков
9. Иосеф болон Түүний ах нар
10. Гэтлэл номын тойм

Курсийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тайлбар

Тэмдэг

1. Та долоо хоног бүр бүлгийн хэлэлцүүлгийн цагийн тодорхой хэсгийг ***Тэмдэгтийн Заавар*** дээр ажиллахад зориулах хэрэгтэй. Энэхүү хоёр нүүр гарын авлага таны Сургагч багшийн үндсэн удирдамж бөгөөд үйлчлэлийн чухал чадвараа хөгжүүлэхийг зорьж буй танд туслах болно.
2. Сургалтын эхний долоо хоногуудад хэлэлцүүлгийн цаг нь Тэмдэгтийн Зааварт буй ***Хэлэлцэх Сэдвүүдийн*** дагуу явах болно.
3. Багийн хэлэлцүүлгээр дамжуулан бат бөх сууриа тавьсан гэж үзвэл үлдсэн долоо хоногуудад нь тэмдэгийн зааврын ***Хэрэгжүүлэх Даалгавар*** дээр ажиллаарай.
4. Хэрэв сургагч багш тань таныг Тэмдэгтийн зааврын дагуу хэрэгжүүлэх алхмуудаа бүрэн гүйцэтгэсэн гэж тооцвол тэмдэгтээр шагнах болно.

Модуль/хичээлүүд

1. *Хичээлүүдийг* судлахдаа **видео хичээл** үзэх ба хүсвэл **аудио хичээл** сонсож, **текст хувилбарыг** уншиж болно.
2. Хичээл бүрийн **Суралцах Хөтчийг** гүйцэт бөглөөрэй. Суралцах хөтөч нь таныг цахим сорил (Дүгнэлт асуултууд) өгөхөд бэлдэх болно.
3. Хичээл бүрийн **цахим сорилыг** (Дүгнэлт асуултууд) бөглөөрэй. Та хэдэн ч удаа сорил өгч болно. Гэвч сорилыг дахин өгөхийн тулд нэг цаг хүлээх хэрэгтэй. Таны авсан хамгийн өндөр оноо таны албан ёсны дүнд тооцогдоно. Долоо хоног бүрийн бүлгийн хэлэлцүүлэгт оролцохын өмнө өмнөх хичээлийн агуулгыг үнэн зөв ойлгосон эсэхээ баталгаажуулахын тулд сорил шалгалтандаа хамгийн багадаа 80% дүн авахыг бид танд зөвлөж байна.
4. Та багаараа болон сургагч багштайгаа долоо хоног бүрийн *хэлэлцүүлэгт* оролцохдоо тухайн хичээлийн **Хэлэлцүүлгийн Гарын Авлагыг** ашиглаарай. Эдгээр хэлэлцүүлгүүд нь хичээлийн агуулгыг бүрэн ойлгож, амьдрал болон үйлчлэлдээ зөв зүйтэй хэрэгжүүлэх чадвартай болоход тань амин чухал юм. Видео хичээлийнхээ талаар тус бүр доод тал нь нэг цаг хэлэлцэж, ярилцахыг бид танд зөвлөж байна.

Эцсийн шалгалт

Та шалгалтыг хэдэн ч удаа өгч болно. Гэхдээ дахин өгөхийн тулд нэг цаг хүлээх хэрэгтэй. Таны авсан хамгийн өндөр оноо таны албан ёсны дүнд тооцогдоно. Энэ курсыг бүрэн дүүргэхийн тулд та хамгийн багадаа 80% дүн авсан байх шаардлагатай.

ҮНЭЛГЭЭ

Эцсийн үнэлгээг дараах байдлаар тооцно:

1. Хичээлийн сорил тус бүр 30 оноо.
2. Хичээлийн эцсийн шалгалт 100 оноо.
3. Энэхүү Залбирлын Тэмдэгтийн даалгаврууд дүнд нөлөөлөхгүй боловч та хичээлийг бүрэн дуусгахын тулд заавал цуглуулсан байх ёстой.

Хичээлийн нийт оноо 80%-иас дээш бол тэнцсэн гэж үзнэ.

Энэхүү хичээлийг хамтран бүтээгчдийн нэрс (эрхэлдэг ажил болон байгууллага нь *бичлэг хийгдсэн цаг үеийнх болно*)

Доктор Стив Блакемор Весли Библийн их сургууль. Философийн дэд профессор.

Др. Стефан Ж. Брамер Далласын Теологийн Сургууль. Библийн Тайлалын тэнхимийн эрхлэгч, профессор.

Др. Роберт Б. Чишолм, Жр. Далласын Теологийн сургууль. Хуучин Гэрээ судлалын тэнхимийн эрхлэгч, профессор.

Др. Дон Коллетт Үйлчлэлийн Тринити Сургууль. Хуучин Гэрээний дэд профессор.

Доктор Дориан Кувер-Кокс нь Даллас теологийн семинарын Хуучин Гэрээ судлалын дэд профессор юм.

Др. Брандон Д Кроув нь Вэстминстерийн Теологийн их сургуулийн дэд профессор.

Проф. Томас Эггер Конкордиа Библийн их сургууль. Бичээсийн Теологи судлалын дэд профессор.

Рев. Майкл Ж. Глодо Шинэчлэлийн Теологийн их сургуулийн Орlando кампусын Хуучин гэрээ судлалын дэд профессор.

Др. Дуглас Гропп Техас мужийн Даллас хот дах Редиймер Библийн их сургууль. Хуучин Гэрээний профессор.

Рев. Др. Сиприан К. Гучиенда Техас мужийн Даллас дахь Хайя Ланд Парк Бүх Үндэстний просбитериан чуулган

Др. Жеймс М. Хамилтон бол Өмнөд Баптист теологийн Сургуулийн Библийн теологийн дэд профессор, Кенвудын Баптист сүмийн номлогч пастор.

Др. Гордон Х. Жонстон Далласын Теологийн Сургууль. Хуучин Гэрээ Судлалын профессор.

Доктор Карол Камински Гордон-Конвелл теологийн семинарын Хуучин Гэрээний профессор юм.

Др. Риад Кассис нь олон улсын Христэд итгэгч удирдлага сургалтын Оверсийс Зөвлөлийн Бүсийн захирал

Др. Грейг С. Кийнэ Асбури Теологийн Сургууль. Библи Судлалын Ада Томпсон тэнхимын эрхлэгч.

Др. Давид Ламб нь Библийн Теологийн их сургууль. Хуучин Гэрээний дэд профессор

Доктор Эрика Мур нь Тринити сургуулийн Хуучин Гэрээ ба Еврей хэлний профессор юм.

Др. Жон Освалт бол Асбери Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний хүндэт зочин профессор юм.

Др. Томас Петтер Гордон-Конвэл Теологийн Сургууль. Хуучин гэрээний дэд профессор.

Др. Ричард Л. Пратт. Жр Гурав дахь мянган үйлчлэлийн ерөнхийлөгч. Шинэчлэлийн Теологийн их сургуулийн Орlando кампусын Хуучин гэрээ судлалын профессор.

Рев. Др. Паул Р. Рааби Конкордиа Библийн Их сургууль. Бичээсийн Теологи судлалын профессор.

Др. Скот Рэд Вашингтон Д.С дэх Шинэчлэлийн Теологийн Сургуулийн Ерөнхийлөгч, Хуучин Гэрээний дэд профессор.

Др. Брайн Д. Рассел Асбури Теологийн Сургууль. Библи Судлалын профессор, Хотын үйлчлэлийн сургуулийн декан.

Доктор Тимоти Э.Салеска Конкордиа Библийн их сургууль. Үйлчлэлийн байгуулал тэнхмийн декан, Бичээсийн теологийн дэд профессор юм.

Др. Дуглас Стюарт Гордон-Конвэл Теологийн Сургууль. Хуучин Гэрээний профессор, Библи Судлалын тэнхмийн эрхлэгч.

Др. Давид Талли Таблот Теологийн Сургууль. Библи болон Теологи Судлалын профессор

Рев. Др. Майкл Вокер Даллас дахь Хайя Ланд Парк Бүх Үндэстний просбитериан чуулган. Орон тооны Теологич

Др. Ларри Ж. Вотерс Далласын Теологийн Сургууль. Библийн тайлалын профессор.

Доктор Майкл Д.Уильямс Ковенант теологийн их сургуулийн системчилсэн теологийн профессор.